



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2001. оны 9. дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 308

Улаанбаатар  
хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Раднаа овогтой Бизъяа, Хишигдэлгэр овогтой Даваадорж нарыг ОХУ-ын Гадаад Хэргийн яамны дэргэдэх дипломатын академид тус тус 2 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Цагдаагийн Ерөнхий газрын 2001 оны 3/1049 тоот албан бичгийг үндэслэн Чойжил овогтой Ганболд, Түвшнээс овогтой Батбаяр нарыг ОХУ-ын Дотоод Явдлын яамны дэргэдэх удирдлагын академид 2 жилийн хугацаагаар, Очирхуяг овогтой Зоригтыг мөн академийн адъюнктурт 3 жилийн хугацаагаар тус тус 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

3. Англи улс дахь АНУ-ын Олон Улсын Их сургуульд суралцаж буй "Оны оюутан" Мэндбаяр овогтой Зулжаргалын суралцах хугацааг нэг жилээр сунгасугай.

4. ОХУ-ын Москвагийн Багшийн Их сургуулийн аспирантурт суралцаж буй Банзрагч овогтой Буяндэлгэр, Дамдинсүрэн овогтой Мөнхжаргал нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

5. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД-г С.Эрдэнэжаргалт А.ЦАНЖИД

Хүчлийн чит: с/м Г.Зандаржавжийн Банж

2001. 9. 18.